



Б.БАЯРСАЙХАН
Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн багш, ахмад, хууль зүйн магистр

ЯЛТНЫ ХӨДӨЛМӨР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

Ялтныг хөдөлмөрлүүлэх тухай асуудлыг ШШГБ-ын эрдэмтэн судлаач, алба хаагчид тодорхой хэмжээгээр судлаж байсан. Энэ удаад ялтны хөдөлмөрлүүлэх асуудалд өнөө үед тулгамдсан асуудлыг нээн гаргаж ирэн тодорхой асуудлыг дэвшүүлэхийг зорилоо.

Ялтныг хөдөлмөрлүүлэх асуудал нь түүхийн арвин их баялагтай. Өнгөрсөн хугацаанд олон гайхамшигтай үр дүнд тухайн үеийн нийгмийн хөгжилтэй уялдан хөгжиж байсан.

Өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудалтай холбогдуулан холбогдох судалгааг хийх нь чухал ач холбогдолтой бөгөөд өнөөгийн бодит байдалд тулгуурлан холбогдох арга хэмжээг авах зүйтэй билээ.

Харин судалгаагаар төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай нийгмийн үеийн хөдөлмөр зохион байгуулалтыг өнөөгийн зах зээлийн нийгмийн хөгжилтэй харьцуулан авч үзвэл зарим нэг онцлог байдал харагдаж байдаг.

Түүхэн үйл явцад ялтны хөдөлмөр зохион байгуулалтыг өөр өөр байдлаар хуульчилсан бөгөөд БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль-ийн 35 дугаар зүйлд “Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллага нь ялтныг засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэх үндсэн

зорилгод захирагдах ёстой” гэж заасан нь Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагаас ялтны хөдөлмөрийг зохион байгуулах ажлын мөн чанар, зорилтыг эрх зүйн хувьд өөрийн гэсэн онцлогтойгоор улам тодорхой болгосон²², 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын хуулийн 120 дугаар зүйлд “Ялтны хөдөлмөр, хөдөлмөрлөх нөхцөл”-ийг хуульчлан баталгаажуулсан бөгөөд ялтны хүмүүжлийн асуудалтай холбож өгөөгүй байдаг.

Эндээс хархад түүхэн явцад хорих байгууллагад ялтныг хөдөлмөрлүүлэх асуудал ялтныг хүмүүжүүлэхэд чиглэгдэж, холбогдох төлөвлөгөөний хүрээнд явагдаж байсан бол өнөөгийн байдлаар нийгмийн онцлогоос /хөгжил/ хамаарч ялтныг хөдөлмөрлүүлэх асуудал анхаарал татах болсон. Энэ нь зах зээлийн хэрэглээ шаардлага, менежменттэй шууд холбоотой бөгөөд ялтныг нийгэмшүүлэх үйл ажиллагаатай шууд холбогдож байна.

Энэ удаад хорих ял эдлэж байгаа ялтныг заавал хөдөлмөрлүүлэх үйл явц нь ялтанд ялын цээрлэл хүлээлгэх, хүмүүжүүлэхэд чухал ач холбогдолтой гэсэн байр суурьнаас биш тэдний хорих байгууллага хөдөлмөрлүүлэх үүрэгтэй гэсэн байр суурийг нөгөө талаас ялтан хөдөлмөр хийж улс нийгмийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах хүмүүжлийн томоохон эерэг нөлөөлөл үзүүлнэ гэсэн байр суурьнаас авч үзэхээр байна. Тэдний /ялтны/ үнэт зүйлсийг тодотгох магадгүй гэмт хэрэгтэн ялтан гэхээр чадваргүй нэгэн байдаг гэсэн үзэл бодлоос үүсэн гарч болзошгүй сөрөг үр дагавраас аль болох зайлсхийх нь чухал байна.

Одоогоор МУ-ын хэмжээнд 6000 гаруй ялтан ял эдлэж байгаагаас ойролцоо тоогоор улиралын шинжтэйгээр 1000-3000 гаруй ялтан ямар нэг хэмжээгээр

²² А.Лхагваа., БНМАУ-ын засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагад хорих ял эдлэгсэдийн хөдөлмөө зохион байгуулалтын зарим асуудал., 1989 он., 9-10 дахь тал



хөдөлмөр эрхэлж байдаг²³ гэсэн тоо баримт байна. Судалгаанаас үзвэл тоосгоны үйлдвэрлэл, блок, шохой, замаск, үржүүлэг, ногоо тарих, чулуу олборлолт, шохой, барилга барих, модон эдлэл, зам засвар, хот тохижилт, хэвлэх үйлдвэрлэл зэрэг 40 гаруй төрлийн ажил үйлчилгээг ялтнуудаар хийлгэж байна. Харин ажил хийх чадвартай ялтнууд нийт ялтны 90 гаруй хувийг эзлэж байна. Энэ нь сүүлийн жилүүдэд нийт ялтны дийлэнх нь хувийг залуучууд эзлэж байгаатайгаар шууд холбогдож байна. Судалгаанаас дээрх ялтнууд тодорхой мэрэгжилгүй байдаг нь ялтныг хөдөлмөрлүүлэх үйл ажиллагаанд тулгамдсан асуудлыг нөхцөлдүүлж байдаг. Харин сүүлийн жилүүдэд мэрэгжилгүй ялтнуудыг “Ялтны мэрэгжил сургалтын төв”-д шаардлагатай мэрэгжилүүдийг эзэмшүүлэн дадлага сургалтыг зохион байгуулж байгаа нь үр дүнтэй сайшаалтай арга хэмжээ болсон.

Харин гянданд ял эдлэж буй ялтнуудын хөдөлмөр эрхлэх асуудлыг хуулиар хориглоогүй ч гянданд хөдөлмөрлүүлэх асуудал анхаарал татсан тулгамдсан асуудлын нэг болж байна. Нэг талаас гяндангийн ялтны онцлогоос хамааруулан аюулгүй байдалд нь түлхүү анхааран гарч болзошгүй учирлаас урьдчилан сэргийлэх төсөөллийн хэмжээнд болгоомжлолыг нөхцөлдүүлж байдаг. Гяндангийн түүхэн эх сурвалжаас үзвэл төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай их бүтээн байгуулалтын үед гянданд ял эдлэж байсан ялтнуудаар гар аргаар чулуу хийлгэж байсан²⁴ гэсэн баримт байдаг ч өнөөгийн байдлаар гяндангийн 30 жилтэй 2 ялтан гяндангийн байранд хэвлэх цехэд ажиллаж байна. Гяндангийн ялтнуудын хувьд зүгээр суухаар ажил хөдөлмөр хийх сонирхол их байдаг боловч тухайн хорих ангийн

онцлогоос хамаарч ялтыг хөдөлмөрлүүлэх асуудал өөрийн гэсэн онцлогийг нээн харуулсан хөдөлмөр зохион байгуулалтын шаардлагатай байна. Энэ асуудлыг шийдвэрлэх нь хэр өгөөжтэй байх талаар төсөөллийн хэмжээнд холбогдох асуудлыг авч үзвэл гянданд хөдөлмөрлүүлэх асуудлын хүрээнд ялтанг хөдөлмөрлүүлснээс үүсэх хор уршгаас болгоомшилсон сэтгэхүй оршсоор байна. Энэ асуудал нь хорих ангийн аюулгүй байдлыг хангаж байгаа асуудал боловч нөгөө талаасаа тухайн ялтанд тохирсон хөдөлмөр зохион явуулах нь зүйтэй. Харин ялтны хөдөлмөрийн хөлсийг бодох нийгмийн гишүүдийн нэгэн адил нийгмийн даатгалд хамруулж цаашид тэтгэвэр авах боломжийг бүрдүүлэх нийгмийн шаардлагын хэрэгцээг хангах нь зүйтэй санагддаг.

Энэ нь нэг талаас тухайн ялтан этгээд суллагдан гархад нийгмийн баталгаа болох зайлшгүй хэрэгцээ байна. Хохиролтой этгээдийн хувьд хохирол төлөгдсөн төлбөр авагчын зүгээс шаардагдах гомдолыг барагдуулхад чухал ач холбогдолтой байдаг зэрэг шалтгаант холбоог харгалзан үзэх шаардлагатай. Мөн дээр дурьдсан асуудлыг шийдвэрлэх нэг арга зам бол ялтнуудаар оюуны хөдөлмөр эрхлүүлэх асуудлыг дэмжсэн бодлого түлхүү барин Иргэний эрх зүйн хүрээнд холдбогдох арга хэмжээг авч байх нь зүйтэй. Ялтан нь Монгол улсын иргэн байхын тухайтад төрийн бодлогыг үйл ажил болгон тэдний оюуны хөгжилд анхаарах нь зүйтэй. Ялтан нь хүн байхын учир тэд эерэг хандлагаар хөгжиж байна гэдэг нийгмийн ирээдүйн аюулгүй байдлыг хангах асуудал билээ. Тэд хэзээ нэгэн цагт суллагдаад нийгэмд хөл нийлүүлэн амьдрах шаардлага урган гарч ирхэд дээрх оюуны хөдөлмөрийнхөө үр шимийг хүртэх бололцоо нээгдэж байна гэсэн үг.

Ялтан ажил хөдөлмөр эрхэлэн нэрийн дансандаа мөнгөтэй болж байгаа асуудал нь практикт ялтны сэтгэхүйд нийгмийн хөгжилтэй уяалдуулан тухайн

²³ ШШГЕГ-ын Ялтны сургалт, хүмүүжлийн хэлтэсийн 2012 оны тайлангаас

²⁴ А.Лхагваа, ШШГБ-ын түүхэн хөгжилт., УБ хот., 2011 он., 48 дахь тал



мөнгөөрөө юу хийж болох боломжийг судлан ярилцаж эдийн засгийн үр өгөөжийг холбогдох мэдээлэлд тулгуурлан ирээдүйн амьдралаа эерэгээр төсөөлөж болох юм. Улмаар дээрх сэтгэхүй хөгжихийн хэрээр тэд амьдрах итгэл үнэмшил нь бүрэлдэн тогтож нийгэмд эзлэх байр суурь нь хөгжих эерэг хандлага харагдаж байна. Нөгөө талаар тэд нэрийн дансан дахь мөнгөнөөсөө тухайн үед ар гэрт нь тулгамдаж буй асуудлыг ч цаг алдалгүй шийдвэрлэх чадвартай болно.

Нөгөөтэйгүүр хоригдогчийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” Монгол улсын хууль²⁵-ийн хэрэгжилтийг хангах талаар шинжлэх ухааны үндэслэлтэйгээр холбогдох ара хэмжээг авах нь зүйтэй. Одоогийн байдлаар ШШГБ-ын зүгээс хөдөлмөр хамгаалалын байцаагчийг томилон үйлдвэрлэлийн болоод хөдөлмөрт хамрагдаж буй ялтнуудад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч холбогдох арга хэмжээг авч байдаг хэдий ч энэ талын мэргэжлийн удирдлагаар хангаж байхын сацуу хөдөлмөр хамгааллын талаархи боловсролыг хөдөлмөр зохион байгуулалттай уяалдуулан явуулах нь зүйтэй.

Мөн ялтны хөдөлмөрийн хөлс, нэгдсэн ажиллагаа тэдгээрийн бүтээмжээс шалтгаалан зах зээл дээр тэднийг ажлуулах хэрэглээ нэмэгдсээр байна. Үүнийг зах зээлийн нийгэмд уяалдуулан явуулах шаардлага урган гарч ирсээр байгаа бөгөөд 2013 оны 02 дугаар сарын 06 ны өдрийн А/33 дугаар тушаалаар “Ялтан гэрээгээр ажиллуулхад мөрдөх заавар”, “Ялтны хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг тогтоох журам” зэргийг баталсан.

Ялтны хөдөлмөрлөх идэвхийг сайжруулах үйл ажиллагааны хүрээнд одоогийн байдлаар шагналын хоног олгох арга хэмжээ авч байгаа боловч энэ нь төдийлөн ялтны хөдөлмөрлөх идэвхийг нэмэгдүүлж байдаггүй боловч энэ талын үйл ажиллагааг цаашид улам бүр боловсронгуй болгох шаардлагатай. Цаашлаад нэрийн дансандаа мөнгөн хөрөнгө төвлөрүүлэх нь олон чухал асуудлыг шийдвэрлэж болох юм. Ялтны хөдөлмөрлөх идэвхийг дээшлүүлэх нь чухал асуудал үүний нэг арга бол тэдний хөдөлмөр хамгааллын асуудал дээр анхаарч доривтой арга хэмжээ авах нь нэг нөлөөллийн хүчин зүйл болно.

Хорих ангид маш их ажиллах хүч агуулагдаж байдаг. Цаашид ялтнуудын ажлын байрыг нэмэгдүүлэх үүднээс төвлөрсөн томоохон үйлдвэрлэл барьж байгуулах, ялтны хөдөлгөөн /орох, гарах/-тэй холбогдуулан хорих анги дахь үйлдвэрлэлд ажиллах хүчийг хуваариллах асуудлыг нарийвчлан судлах нь зүйтэй.

Мөн зах зээл дээр юу шаардлагатай байгаа асуудалд тулгуурлан үйлдвэрлэлийн чиглэлийг тогтоох шаардлагатай.

²⁵ Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсыни байцаагчдын гарын авлага, 2009 он., 1-34 дэх тал

